



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/379

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх зүйл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/371 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос "Томоохон хотууд, аймгийн төвүүдэд агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хэр уршгийг бууруулах, дэвшилтэд техник технологийн талаарх хөтөлбөр хэрэгжүүлэх" ажлын хүрээнд олгосон хөрөнгө оруулалтаар Чингис хотод тоосонцор хэмжих PM10, PM2,5 автомат багаж, түүхийн нүүрсний хэрэглээг бууруулах зорилгоор шахмал түлш үйлдвэрлэх тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга: Ц.Дэмбэрэлсайхан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: О.Сэдэд -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүн: Ц.Бат-Эрдэнэ -Хөрөнгө оруулат, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

